OTGONTENGER
UNIVERSITY
SINCE 1991

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 13 өдөр Дугаар А/56 Улаанбаатар хот

2026-2027 оны хичээлийн жилд
Отгонтэнгэр их сургуулийн бакалаврын хөтөлбөрт
суралцагч элсүүлэх журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/143 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, Боловсролын сайдын 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/34 тоот “Босго оноо тогтоох тухай” тушаал, Отгонтэнгэр их суруулийн ректорын өргөтгөсөн зөвлөлийн 2026 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2026-2027 оны хичээлийн жилд Отгонтэнгэр их сургуулийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх журмын хавсралтаар баталсугай.

2. Журмын дагуу элсэлтийн үйл ажиллагаа зохион байгуулахыг элсэлтийн төв комисс /Ж.Золбаяр/ болон элсэлтийн салбар комисст даалгасугай.

3. 2026-2027 оны хичээлийн жилд элсэлт авах мэргэжил/хөтөлбөр, журмыг сурталчилан таниулахыг Сургалтын нэгдсэн албаны дарга /Л.Мягманхүү/, маркетингийн албаны дарга /Э.Энхсайхан/ нарт даалгасугай.

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬ УДМ03030 2026961

РЕКТОР Н.ЭНХЗАЯА

Ректорын 20 26 оны 04 сарын
13 өдрийн 148 тоот
тушаалын хавсралт

2026-2027 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/143 тоот тушаалаар батлсан "Оюутан элсүүлэх журам", Боловсролын сайдын 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/34 тоот "Босго оноо тогтоох тухай" тушаал болон бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журам /цаашид "журам" гэх/-ыг баримтлана.

1.2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон шаардлага, дээд боловсролын сургалтын орчны болон холбогдох стандартад нийцүүлэн сургуулийн Удирдах зөвлөлөөс батлсан хяналтын тоонд багтаан Отгонтэнгэр их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлнэ.

1.3. Энэхүү журам нь ОТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2026-2027 оны хичээлийн жилд суралцагч бүртгэх, ур чадварын шалгалт авах, оноогоор эрэмбэлэх, мэргэжил сонголт хийх, баталгаажуулах, элсүүлэх үйл явцыг зохицуулна.

1.4. ОТИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг "бүртгүүлэгч", Удирах зөвлөлөөс батлсан хөтөлбөрт элсүүлэх суралцагчийн тоог "хяналтын тоо", элсэлтийн хяналтын тоонд багтан элсэх эрх авсан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн цахим бүртгэлийн системийг "элсэлтийн систем", элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг "элсэлтийн комисс", ур чадварын шалгалтыг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг "ур чадварын шалгалтын комисс", элсэлтийн цахим хуудаст нэвтэрч хувийн мэдээллээ оруулсан болон биеэр ирж элсэх хүсэлтэй, хэд хэдэн хөтөлбөрийг сонгож төлбөр төлж баталгаажуулах үйл явцыг "элсэлтийн бүртгэл", Монгол Улсын иргэний харьяалалгүй буюу гадаад улсын харьяалалтай иргэнийг "гадаадын иргэн" гэнэ.

1.5. ОТИС-д гадаадын иргэнийг элсүүлэх асуудлыг "Отгонтэнгэр их сургуульд гадаадын иргэнийг суралцуулах журам"-аар зохицуулна.

ХОЁР. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцсан байх

2.2. Элсэлтийн шалгалт /ЭШ/ өгсөн бүртгүүлэгч нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

2.2.1. Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой байх

2.2.2. ОТИС-ийн элсэлт авах хөтөлбөр/мэргэжилд харгалзах суурь хичээлийн аль нэг, мөн дагалдах хичээлийн аль нэг хичээлээр ЭШ өгч энэхүү элсэлтийн журамд заасан босго онооны болзлыг хангасан байх

2.2.3. Ур чадварын шалгалт тооцох хөтөлбөрт бүртгүүлэгч нь ОТИС-аас зохион байгуулсан ур чадварын шалгалт өгч, босго онооны шаардлагыг хангасан байх

2.2.4. Бүртгүүлэгчийн ЭШ-ын батламж нь шалгалт өгсөн өдрөөс хойш 2 жил 8 сарын хугацаанд хүчинтэй байх нөхцөлийг хангасан, эсхүл 2026 онд ЭШ өгөхөөр БҮТ-д бүртгүүлсэн байх

2.3. ОТИС-ийн бакалаврын хөтөлбөрт суралцах хүсэлтэй, дараах шалгууруудын аль нэгийг хангасан бүртгүүлэгч ЭШ өгөхгүйгээр шууд элсэж болно. Үүнд:

2.3.1. Дэд бакалавр, бакалаврын боловсролтой иргэн /гадаадад боловсрол эзэмшсэн бол БМИҮЗ-өөр батлагаажуулан ДБУМС-д бүртгэгдсэн байх/;

2.3.2. Политехник коллеж, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгч;

2.3.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 байрт шалгарсан иргэн тухайн чиглэлийн хөтөлбөрт;

2.3.4. Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшин, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноог Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаар дүйцүүлэн тооцуулж батламж авсан иргэн;

2.3.5. Гадаадын аль нэг улсын дээд боловсролын сургалтын байгууллагаас ОТИС-ийн ижил түвшний хөтөлбөрт шилжин суралцах иргэн;

2.3.6. ОТИС-д элсэлт авах бакалаврын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-ээр 3-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш насны иргэн;

2.4. Бакалаврын хөрвөх /хавсралт 3/ хөтөлбөрийн хичээлийн хэлбэр /танхим, цахим эсвэл хосолсон хэлбэр/-ийг бүртгүүлэгчийн тоо, багшийн ачаалал зэргийг харгалзан хөтөлбөр хэрэгжүүлэх сургууль, тэнхим элсэгч бүртгүүлэгчдэд ОТИС-ийн цахим хаяг болон бусад нийгмийн сүлжээгээр мэдэгдэнэ.

2.4.1. Журмын 2.3.1-д заасан дэд бакалавр, бакалаврын боловсролтой иргэнийг өдрийн үндсэн болон хөрвөх ангид элсүүлэн суралцуулна.

2.5. Журмын 2.3.1, 2.3.2, 2.3.5 заалтын дагуу бакалаврын хөтөлбөрт элсэн суралцах иргэний өмнө эзэмшсэн боловсролын диплом эсхүл суралцсан хугацааны дүнгийн тодорхойлолтыг үндэслэн “Сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэн тооцох журам”-ын ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлийн боломжит хичээлүүдийг дүйцүүлэн тооцно. Энэ тохиолдолд сургалтын төлбөрт өөрчлөлт орохгүй.

2.6. Журмын 2.3.4 заалтын болзол хангасан бүртгүүлэгчийг олон улсын шалгалтын дүйцүүлсэн оноог нь үндэслэн бүртгэж, ЭШ өгсөн элсэгчдийн хамт эрэмбэлэн хөтөлбөр сонгуулна.

2.7. Журмын 2.3.6 заалтын дагуу элсэх бүртгүүлэгчийг ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгал төлсөн лавлагаа, өргөдөл болон эсээ /суралцах бэлтгэл хангасан байдал, авьяас чадвар, туршлага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлэх гэх мэт агуулгыг тусгасан/ бичсэн байдал зэргийг үндэслэн элсүүлнэ.

ГУРАВ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

3.1. 2026-2027 оны хичээлийн жилийн намрын улирлын элсэлтийн бүртгэлийг 2026 оны 4 дугаар сарын 15-ны өдрийн 10:00 цагаас нээж, мөн оны 6 дугаар сарын 29-ний өдөр 22:00 цагт хаана. Хаврын улирлын элсэлтийн бүртгэлийг 2026 оны 2 дахь удаагийн ЭШ-ын хуваарьтай нийцүүлэн зарлах, элсэлт зохион байгуулна. Байгууллага, зах зээлийн эрэлтээс хамаарч зуны элсэлт зохион байгуулж болно.

3.2. ОТИС-ийн бакалаврын хөтөлбөрийн элсэлтийн бүртгэлийг элсэлтийн https://elselt.otu.edu.mn цахим хаягаар болон сургуулийн байранд зохион байгуулна.

3.3. Хяналтын тоо, элсэгчдийн тооноос хамаарч нэмэлт элсэлтийг тухайн улирлын хичээл эхлэхээс өмнө элсэлтийн комисс зохион байгуулна.

ОТГОНТЭНГЭР
ИХ СУРГУУЛЬ

3.4. Бүртгүүлэгч нь БҮТ-ийн системд нэвтэрдэг бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан ОТИС-ийн элсэлтийн системд нэвтэрч, зааврын дагуу элсэх хүсэлтээ гаргана.

3.5. Бүртгүүлэгч нь элсэлтийн системд шаардлагатай мэдээллээ үнэн зөв оруулан, бүртгэлийн хураамжийг цахимаар төлж баталгаажуулснаар бүртгэл хүчин төгөлдөр болно.

3.6. Бүртгүүлэгч нь элсэлтийн системд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах ба алдаатай, буруу мэдээлэл оруулснаас үүсэх хариуцлагыг ОТИС хүлээхгүй.

3.7. Бүртгэлийн хураамж нь хавсралт 1-д дурсан хөтөлбөр тус бүрт 10,000 төгрөг, хавсралт 3-т дурдсан хөтөлбөр тус бүрт 15,000 төгрөг байх ба бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

3.8. Хавсралт 1-д заасан бакалаврын хөтөлбөрүүдийг ОТИС хариуцан хэрэгжүүлэх ба элсэгч сургалтын төлөвлөгөөнд заасан сургалтын хугацаандаа зохих багц цагийг гүйцэтгэснээр төгсөх болзол хангана.

3.9. Хавсралт 2-т заасан гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөрийн эхний 2 эсвэл 3 жилийн сургалтыг ОТИС-ийн бүтцийн сургууль, сүүлийн жилүүдийн сургалтыг хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэгч гадаад улсын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нэгж тус тус хариуцах ба төгсөх болзол хангасан суралцагчид 2 сургуулийн бакалаврын зэрэг, диплом олгох ба нийт суралцах хугацаа нь 5.5 жилээс ихгүй байна. Гадаадын их сургуулиудад суралцах хугацааны сургалтын төлбөр нь хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэгч гадаадын сургуулийн төлбөр байна.

3.10. Хавсралт 3-т заасан бакалаврын хөрвөх хөтөлбөрт элсэгчийн бүртгэл нь улирлын хичээл эхлэхээс өмнө 30 хоног байх ба бүртгэл дуусах хугацааг элсэлтийн комисс тусгайлан нийтэд ил тод зарлан зохион байгуулж, хөтөлбөрүүдийг бүтцийн сургууль хариуцан хэрэгжүүлэх ба элсэгч нь сургалтын төлөвлөгөөнд заасан хичээл, багц цагийг тооцуулснаар төгсөх болзол хангана.

ДӨРӨВ. УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ

4.1. Дагалдах хичээлд ур чадварын шалгалт тооцох хөтөлбөрүүдийн шалгалтыг элсэлтийн бүртгэл дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан томилогдсон комисс удирдамжийн дагуу зохион байгуулж, шалгалтын дүнг батална.

4.2. Зах зээлийн эрэлт хэрэгцээ, хяналтын тоонд үндэслэн ур чадварын шалгалтыг нэмэлт элсэлтийн үед зохион байгуулж болно.

4.3. Ур чадварын шалгалтыг 0-100 оноогоор үнэлэх ба хүснэгт 1-д үзүүлсэн аргачлалаар хэмжээст оноонд шилжүүлнэ.

Хүснэгт 1

Шалгалтын оноо буюу анхны оноо (А)	0-59	60-64.9	65-69.9	70-74.9	75-79.9	80-84.9	85-89.9	90-94.9	95-100
Хэмжээст оноо (Х)	200-489	490-528	529-567	568-605	606-644	645-683	684-722	723-760	761-800
Бодох томьёо	Х=200+А*4.84				Х=490+(А-60)*7.75				

4.4. Ур чадварыг шалгалтын хэмжээст оноог дагалдах шалгалтад тооцох ба ур чадварын шалгалтын хэмжээст оноо нь тухайн хөтөлбөрийн босго онооноос байгагүй тохиолдолд тухайн ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

4.5. "Хөгжлийн бэрхшээлтэй элсэгчээс авах ур чадварын шалгалтыг тухайн хүний бие эрхтний онцлогт тохирсон хэлбэрээр (дойт, брайль, дохионы хэлмэрчтэй гэх мэт) зохион байгуулах, зарим мэргэжлийн онцлогоос хамаарч тусгай зохицуулалт хийх тухай "Ур чадварын шалгалтын зохион байгуулах удирдамж"-д тусгана.

ТАВ. ОНООНЫ ЖАГСААЛТ, ХӨТӨЛБӨР СОНГОЛТ

5.1. Элсэлтийн бүртгэл хаагдсаны дараа бүртгэлээ баталгаажуулсан бүртгүүлэгчдийн ЭШ-ын оноог БҮТ-ийн серверээс ОТИС-ийн элсэлтийн системд татаж суурь ба дагалдах /зарим хөтөлбөрт ур чадварын шалгалт/ хичээлийн онооноос бүртгүүлэгчдийн оноог хөтөлбөр бүрээр босго оноотой харьцуулан эрэмбэ үүсгэнэ.

5.2. Бүртгүүлэгчийн суурь болон дагалдах шалгалт нь тус бүр 50% байх ба суурь шалгалтад тооцуулсан оноог дагалдах шалгалтад давхар тооцохгүй.

5.3. Жагсаалтын оноо тэнцсэн тохиолдолд гүйцэтгэлийн хувиар байр эзлүүлж элсэх эрх олгох ба гүцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана.

5.4. Бүртгүүлэгчийн оноог энэ журмын Хавсралт 1-д заасан шалгалтын хичээлийн чиглэл, оноогоор тооцно.

5.5. Хөтөлбөр сонголтыг элсэлтийн цахим хаягаар дамжуулан явуулна.

5.6. Бүртгүүлэгч нь хяналтын тоонд багтсан эсэхээ онооны жагсаалт гарсны дараа элсэлтийн системд нэвтэрч шалгана.

5.7. Намрын улирлын элсэх эрх олгох үйл ажиллагааг 2026 оны 7 сарын 01-ний өдрийн 10:00 цагт эхлүүлж, мөн оны 7 сарын 09-ний өдрийн 15:00 цагт дуусгана. Хаврын болон зуны элсэлтийн хугацааг тухайлан зарлан хэрэгжүүлнэ.

5.8. Бүртгүүлэгч хяналтын тоонд багтсан бол зөвхөн нэг хөтөлбөр сонгох ба сонголт хийгээгүй бол хөтөлбөрийн жагсаалтаас бүртгүүлэгчийн нэр хасагдаж хяналтын тоонд шинээр багтсан бүртгүүлэгч хөтөлбөр сонгох эрхтэй болно.

5.9. Бүртгүүлэгч хөтөлбөр сонголт хийхдээ хөтөлбөр баталгаажуулалтын 1,000,000 төгрөгийг төлж баталгаажуулна.

5.10. Тогтоосон хугацаанд хөтөлбөр сонголт, баталгаажуулалт хийгээгүй тохиолдолд хөтөлбөр сонголтоос татгалзсан гэж үзэн жагсаалтын дараагийн бүртгүүлэгчид хөтөлбөр сонгох эрхийг олгоно.

5.11. Хөгжлийн бэрхшээлтэй элсэгчийн хүсэлтийг харгалзан хөтөлбөр сонгох хугацааг сунгаж болно.

ЗУРГАА. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

6.1. Хяналтын тоонд багтсан бакалаврын өдрийн хөтөлбөрт бүртгүүлэгч нь дараах материалыг бүрдүүлэн 2026 оны 07-р сарын 15-ны өдрөөс 07-р сарын 22-ны хооронд ажлын цагаар элсэлтийн бүртгэлийн хэсэгт ирж элсэгчийн анкет бөглөн оюутны код, нууц үгээ авч суралцах эрхээ баталгаажуулна[1].

- 3х4 хэмжээтэй цээж зураг 2% /сүүлийн гурван сард авахуулсан/
- ЭШ-ийн батламж /БҮТ-ийн цахим хуудаснаас хэвэлсэн байна/
- бүрэн дунд боловсролын гэрчилгээ /эх хувь/
- сурагчийн хувийн хэрэг/ эх хувь/
- сургалтын төлбөр [2] төлсөн баримтыг битүүмжлэл сайтай хавтаст хийсэн байна.

---

[1] Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан материал авах хугацааг жич зарлаж болно.

[2] Хуваарь баталгаажуулалт, элсэх эрхийн 1,000,000 төгрөг төлсөн байх, уг төлбөрийг сургалтын төлбөрт оруулан тооцно.

6.2. Элсэгч нь 2026 оны 9 сарын 07-оос эхлэн оюутны код, нууц үгээ ашиглан оюутны вэбд суралцах гэрээг цахимаар байгуулна. Цахимаар байгуулсан гэрээ нь цаасан суурьтай гэрээтэй ижил хүчин төгөлдөр үйлчилнэ. Элсэгч суралцагч нь сургалтын гэрээг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид танилцуулах үүргийг хүлээнэ.

6.3. Журмын 6.1-д заасан хугацаанд бүртгүүлж, суралцах гэрээ байгуулаагүй элсэгчийн ОТИС-д суралцахаас татгалзсан гэж үзэж эрхийг хүчингүйд тооцно.

6.4. Бичиг баримтаа хураалгасан ч хичээлийн улирал эхлэхээс өмнө элсэх эрхээсээ татгалзан тохиолдолд бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн бичиг баримтыг элсэлтийн комисс буцааж олгоно[3].

6.5. Агаарын тээврийн үйлчилгээ хөтөлбөрөөр элсэгчийн дүрэмт хувцасны төлбөр нь сургалтын төлбөртөө багтсан байна[4]. Хуваарь баталгаажуулалтын төлбөрөө төлснөөр дүрэмт хувцас авах эрх үүснэ.

6.6. Бакалаврын хөрвөх хөтөлбөр /хавсралт 3/-т элсэгчийн бүртгэл

6.6.1. Бүртгүүлэгчийн өмнөх бакалаврын зэргийн бичиг баримт нь Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгэгдсэн байна.

6.6.2. ОТИС-ийн элсэлтийн системийн орой эчнээ элсэлт хэсэгт нэвтэрч маягт бөглөн бүртгэлийн хураамж 15,000 төгрөгийг төлж суралцах хөтөлбөрөө сонгоно.

6.6.3. Элсэгч нь дараах материалыг бүрдүүлэн улирлын хичээл эхлэхээс 14 хоногийн өмнө сургалтын албанд хүргүүлсэн байна.

- 3х4 хэмжээтэй цээж зураг 2% /сүүлийн гурван сард авахуулсан/
- иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар
- өмнө нь эзэмшсэн боловсролын диплом хавсралтын хамт /гадаадад боловсрол эзэмшсэн бол албан ёсны орчуулгыг эх хувиар нотариатаар батлуулсан байх/
- элсэгчийн анкет
- сургалтын төлбөр төлсөн баримтыг битүүмжлэл сайтай хавтаст хийсэн байна.

6.7. Элсэлтийн материалыг хуурамчаар бүрдүүлсэнтэй холбогдон гарах хариуцлагыг хүсэлт гаргагч буюу бүртгүүлэгч өөрөө хүлээнэ.

6.8. Журмын 5.9-д дурдсан хөтөлбөр баталгаажуулалтын төлбөр нь сургалтын төлбөрт тооцогдоно. Элсэгч нь баталгаажуулсан хөтөлбөрөө цуцлах тохиолдолд дараагийн бүртгүүлэгчийн хөтөлбөр сонгох боломжийг хаасан үндэслэлээр хүндэтгэн үзэх шалтгааныг үл харгалзан баталгаажуулалтын төлбөрийн 20%-ийг суутган үлдсэн төлбөрийг буцаан олгоно.

6.9. Журмын 5.9-д дурдсан хөтөлбөр баталгаажуулалтын төлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй элсэгчид хамаарахгүй.

ДОЛОО. ЭЛСЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ,ТЭТГЭЛЭГ

7.1. 2026-2027 оны хичээлийн жилийн намрын элсэлтийн бакалаврын үндсэн хөтөлбөрт элсэн суралцагч нь тус хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 2026 оны 7 сарын 24-ний дотор бүрэн төлсөн тохиолдолд 10 хувийн хөнгөлөлт эдэлнэ.

7.2. Элсэлтийн ерөнхий шалгалтын оноонд үзүүлэх хөнгөлөлт

7.2.1. Суурь шалгалт 751-800 оноотой элсэгч эхний хичээлийн жилийн төлбөр – 100% (АТҮ-ний хөтөлбөрт -40%)

---

[3] Хуваарь баталгаажуулалт, элсэх эрхээ цуцалсан тохиолдолд дараагийн бүртгүүлэгч хуваарь авч чадахгүйд хүрдэг тул 20%-ийн буюу 200,000 төгрөгийг суутгана.

[4] Дүрэмт хувцасаа авсан тохиолдолд хуваарь баталгаажуулалт, элсэх эрхийн төлбөрийг буцаахгүй

7.2.2. Суурь шалгалт 701-750 оноотой элсэгч эхний хичээлийн жилийн төлбөр – 75% (АТҮ-ний хөтөлбөрт -35%)

7.2.3. Суурь шалгалт 650-700 оноотой элсэгч эхний хичээлийн жилийн төлбөр – 50% (АТҮ-ний хөтөлбөрт -30%)

7.3. БЯ-аас тогтоосон Олон улсын болон улсын олимпиадын амжилтад үзүүлэх хөнгөлөлт

7.3.1. Олон улсын олимпиадад оролцож 1-ээс 3-р байрт шалгарсан элсэгчид эхний жилийн сургалтын төлбөрийн 100%

7.3.2. Улсын олимпиадад оролцож 1-р байрт шалгарсан элсэгчид эхний жилийн сургалтын төлбөрийн 100%

7.3.3. Улсын олимпиадад оролцож 2-р байрт шалгарсан элсэгчид эхний жилийн сургалтын төлбөрийн 75%

7.3.4. Улсын олимпиадад оролцож 3-р байрт шалгарсан элсэгчид эхний жилийн сургалтын төлбөрийн 50%

7.4. Элсэн суралцагч нь “ОТИС-ийн оюутанд тэтгэлэг олгох, хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх журам”-д заасан хөнгөлөлтөө зөвхөн тус сургуульд суралцаж байх хугацаандаа эдлэх боломжтой.

7.5. Журмын[5] хоёрдугаар зүйлийн холбогдох заалтын тавигдах шаардлагыг хангасан, холбогдох бичиг баримтыг тогтоосон хугацаанд бүрдүүлж, гэрээ байгуулсан бол төрөөс төлбөрийг бүрэн санхүүжүүлнэ.

7.6. Журмын [6] 7.2.1-д дурдсан “Нийгмийн ажил” болон 7.2.4-д дурдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн Сэтгэл зүй /Сэтгэл судлал/ мэргэжлийн үндсэн хөтөлбөрөөр элсэн суралцагч нь төгссөнөөс хойш орон нутгийн байгууллагад 3 жил, нийслэлд 5 жил мэргэжлээрээ тогтвортой ажиллах нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн байх ба элсэлтийн шалгалтад тухайн мэргэжлийн чиглэлийн суурь болон дагалдах шалгалтад тус бүр 501-ээс дээш оноо авсан тохиолдолд 100 хувийн, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улиралд 3.0, түүнээс дээш голч дүнтэй суралцсан тохиолдолд 100 хувийн, 2.8-3.0 хүртэл голч дүнтэй суралцсан тохиолдолд 70 хувийн Боловсролын зээлийн сангийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамрагдаж болно.

7.7. Бакалаврын хөрвөн суралцах хөтөлбөрт элсэн суралцагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн бол сургалтын төлбөрийг эхний улиралд 30 хувийн, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улиралд 3.2, түүнээс дээш суралцсан тохиолдолд 30 хувийн, 2.8-3.2 хүртэл голч дүнтэй суралцсан тохиолдолд 15 хувийн хөнгөлөлт олгоно.

7.8. Журмын[6] наймдугаар зүйлийн “Зорилтот бүлгийн суралцагчид олгох буцалтгүй тусламж”-д заасан бүтэн өнчин суралцагч; нэг гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй өрхийн хагас өнчин суралцагч; хөгжлийн бэрхшээлтэй суралцагч; эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй өрхийн нэг суралцагч; хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагч; цаатан, тува, урианхай үндэстний өрхийн нэг суралцагч; нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дотоодын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр зэрэг суралцаж байгаа бол нэг суралцагч нь гурван талт гэрээг байгуулан буцалтгүй тусламжаар үргэлжлүүлэн буцалтгүй тусламжид хамрагдана. Зорилтот бүлгийн суралцагчийн өмнөх улирлын голч дүн 2.0 буюу түүнээс дээш бол буцалтгүй тусламжийн нөхцөлөөр үргэлжлүүлэн суралцана.

7.9. Хөгжлийн бэрхшээлтэй элсэгчид хамаарах заалтын хэрэгжилтэд нотлох хууль ёсны бичиг баримт /комиссын шийдвэр/-ыг бүрдүүлсэн байна.

---

[5] МУ-ын Засгийн Газрын 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 103 тоот тогтоол “Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”

[6] МУ-ын Засгийн Газрын 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 215 тоот тогтоол “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам”

НАЙМ. БУСАД

8.1. Цахим бүртгэл явагдаж байх үед бүртгүүлэгчдэд зөвлөгөө өгөх үйл ажиллагааг элсэлтийн бүртгэлийн систем, мессенжер, facebook, утас, цахим шуудан ашиглан явуулна.

8.2. Бүртгүүлэгч нь элсэлтийн системээр нэвтэрч энэхүү журамтай бүрэн танилцаж зөвшөөрсөн нь хөтөлбөр сонгосноор баталгаажна.

8.3. Бүртгүүлэгч элсээгүй тохиолдолд сургалтын төлбөр буцаан авах хүсэлтээ 2026 оны 9 сарын 10-ны дотор гаргана. Энэхүү хугацаанаас хойш төлбөр буцаах хүсэлтийг шалтгаан үл харгалзан хүлээн авахгүй ба төлбөрийг буцаан олгохгүй.

8.4. Элсэлтийн комисс нь элсэлттэй холбоотой үйл ажиллагааг шударга явуулах, элсэгчдийг үнэн бодит мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд ямар нэгэн байдлаар зохисгүй үйлдэл гаргасан бол “Отгонтэнгэр их сургуулийн дотоод журам”, “Отгонтэнгэр их сургуулийн багшийн ёс зүйн дүрэм”-ийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.5. Элсэлттэй холбоотой аливаа маргааныг элсэлтийн комисс эцэслэн шийдвэрлэнэ.

Хаяг: БЗД, 5-р хороо, Жуковын музейн зүүн талд
Утас: 70101991, 77231991, 95101991
Элсэлтийн цахим бүртгэлийн систем: http://elselt.otu.edu.mn
E-mail:info@otgontenger.edu.mn
Web site: www.otgontenger.edu.mn
Сургалтын төлбөр төлөх данс: ХААН банк MN83 0005 00 5753885058

2026-2027 оны хичээлийн жилд Отгонтэнгэр их сургуулийн
бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх
журмын хавсралт 1

Бакалаврын өдрийн хөтөлбөр, шалгалтын нэр, онооны шалгуур

№	Индекс	Хөтөлбөрийн нэр	ЭШ-1 Суурь шалгалт /аль нэгээр заавал босго оноог давсан байх/		ЭШ-2 Дагалдах шалгалт /аль нэгээр заавал босго оноог давсан байх/	
			Хичээлийн нэр	Босго оноо	Хичээлийн нэр	Босго оноо
1	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол	Монгол хэл, Нийгэм судлал, Математик	440	Ур чадвар	490
2	011430	Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол	Монгол хэл, Нийгэм судлал	490	Ур чадвар	490
3	011435	Багш, гадаад хэлний боловсрол /англи хэл/	Англи хэл, Орос хэл, Монгол хэл	490	Ур чадвар	490
4	023101	Гадаад хэлний орчуулга /хят.хэл, сол.хэл/	Англи хэл, Орос хэл, Математик	490	Нийгэм судлал, Монгол хэл, Түүх	490
5	031202	Олон улсын харилцаа	Англи хэл, Орос хэл	490	Нийгэм судлал, Түүх	490
6	031301	Сэтгэл судлал	Нийгэм судлал, Математик	490	Монгол хэл, Англи хэл	490
7	032101	Сэтгүүл зүй	Монгол хэл, Нийгэм судлал, Англи хэл	490	Ур чадвар	490
8	041101	Нягтлан бодох бүртгэл	Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	490
9	041201	Санхүү, банк	Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	490
10	041301	Бизнесийн удирдлага	Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	490
11	041304	Хүний нөөцийн менежмент	Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	490
12	041401	Маркетинг	Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	490
13	042101	Эрхзүй	Нийгэм судлал	490	Математик, Англи хэл	490
14	042103	Бизнесийн эрх зүй	Нийгэм судлал	490	Математик, Англи хэл	490
15	061302	Программ хангамж	Математик, Физик	490	Нийгэм судлал, Англи хэл	450
16	092301	Нийгмийн ажил	Нийгэм судлал, Англи хэл	490	Монгол хэл, Математик	490
17	101501	Аялал жуулчлал	Газар зүй, Математик, Англи хэл	490	Ур чадвар	490
18	104102	Агаарын тээврийн үйлчилгээ	Англи хэл, Нийгэм судлал	490	Ур чадвар	480

Жич: Журмын 2.3.6 шаардлага хангасан элсэн суралцагчийн суралцах хугацаа нь 3,5 жил байна.

--oOo--

2026-2027 оны хичээлийн жилд Отгонтэнгэр их сургуулийн
бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх
журмын хавсралт 2

Хамтарсан бакалаврын өдрийн хөтөлбөр, шалгалтын нэр, онооны шалгуур

№	Индекс	Хөтөлбөрийн нэр	ЭШ-1 Суурь шалгалт /аль нэгээр заавал босго оноог давсан байх/		ЭШ-2 Дагалдах шалгалт /аль нэгээр заавал босго оноог давсан байх/	
			Хичээлийн нэр	Босго оноо	Хичээлийн нэр	Босго оноо
1	031202	Олон улсын харилцаа	Англи хэл, Орос хэл	490	Нийгэм судлал, Түүх	490
2	031301	Сэтгэл судлал	Нийгэм судлал, Математик	490	Монгол хэл, Англи хэл	490
3	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол	Монгол хэл, Нийгэм судлал, Математик	440	Ур чадвар	490
4	104104	Агаарын тээврийн үйлчилгээ	Англи хэл, Нийгэм судлал	490	Ур чадвар	480

--oOo--

2026-2027 оны хичээлийн жилд Отгонтэнгэр их сургуулийн
бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх
журмын хавсралт 3

Бакалаврын хөрвөх хөтөлбөр, суралцах хугацаа, элсэгчдэд тавигдах шаардлага

№	Индекс	Хөтөлбөрийн нэр	Суралцах хугацаа	Элсэгчдэд тавигдах шаардлага
1	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол	1,5 жил	Багш мэргэжилтэй байх
2	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол	2,0 жил	Бакалаврын зэрэгтэй байх
3	011430	Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол	2,0 жил	Бакалаврын зэрэгтэй байх
4	011435	Багш, гадаад хэлний боловсрол /англи хэл/	2,0 жил	Бакалаврын зэрэгтэй байх
5	023101	Гадаад хэлний орчуулга /англи, хятад, солонгос/	2,0 жил	Бакалаврын зэрэгтэй байх
6	031301	Сэтгэл судлал	2,0 жил	Бакалаврын зэрэгтэй байх
7	032101	Сэтгүүл зүй	2,0 жил	Бакалаврын зэрэгтэй байх
8	041101	Нягтлан бодох бүртгэл	2,0 жил	Бакалаврын зэрэгтэй байх
9	041301	Бизнесийн удирдлага	2,0 жил	Бакалаврын зэрэгтэй байх
10	042101	Эрх зүй	2-2,5 жил	Бакалаврын зэрэгтэй байх
11	042103	Бизнесийн эрх зүй	2-2,5 жил	Бакалаврын зэрэгтэй байх
12	092301	Нийгмийн ажил	2,0 жил	Бакалаврын зэрэгтэй байх

--oOo--